

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт -гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ Зорилт 1.1.“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Тайлант хугацаанд нийт Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, тогтоол, тушаал, заавар, зөвлөмж, аргачлал, загвар, чиглэл, тайлбар, судалгаа болон бусад албан бичиг, дээд газраас ирүүлсэн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмжийг хүлээн авч хэлтсийн хариуцах ажилтан албан хаагчдад тухай бүрд шилжүүлэн албан бичгүүдийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.	
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							

Зорилт 2: "Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгээрийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1.	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах.		Нийгмийн даатгалын сангийн 2025 оны орлого, зарлагын гүйцэтгэл	Нийгмийн даатгалын санд 2025 онд 332 854,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэмж, төлбөр, зардалд 12,170.3 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05/777 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Нийгмийн даатгалын төвлөрсөн орлого дансанд нийт 332 854,6 сая төгрөгийн орлого төвлөрснийг нийт 6 банкны төвлөрсөн орлогын дансаар хүлээн НДЕГ-ын төвлөрсөн орлогын сангийн дансанд өдөр бүр төвлөрүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8,184 сая төгрөг батлагдсанаас 8,298.4 сая төгрөг зарцуулагдсан нь жирэмсэн амаржсаны тэтгэмж 4,854.4 сая төгрөгийн зардлаас 4,577.6 сая төгрөг зарцуулагдаж 276.8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан харин хчтат, нбдагот зардал 3,329.6 сая төгрөг батлагдсанаас 3,720.8 сая төгрөгийн зардалтай гарч 391.2 сая төгрөгийн хэтрэлттэй гарч байна. Сангийн зардлаас ажилгүйдлийн даатгалын сангийн зардал эхний хагас жилийн байдлаар 3,871.9 сая төгрөгийн санхүүжилт орж ирснээс 3,871.9 сая төгрөгийн зардал гарч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 400.0-550.0 сая
------	---	--	--	--	--	---

						төгрөгөөр хэтэрсэн дүнтэй бөгөөд НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх саналаа хүргүүлэн ажиллаж байна.	
2.2.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.	-	Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.	Төрийн үйлчилгээг шуурхай чанартай хүргэх зорилгоор арилжааны банкуудтай байгуулсан гэрээний дагуу Ажил олгогч даатгуулагчдын ХЧТА болон ЖА-ын тэтгэмжийн олголтыг тэтгэмжийн улсын байцаагчаар хянуулж баталгаажуулсны дараа гүйлгээний жагсаалтаар 7 хоногт 3-5 удаа гүйлгээ хийж олгож хэвшүүлсэн. Ажилгүйдлийн тэтгэмжийг сар бүрийн 20-25-ны хооронд жагсаалтаар, мөн тухайн сарын 25-наас хойш тэтгэмжийн баримт бичиг бүрдүүлэн өгсөн даатгуулагчдын тэтгэмжийг тогтоон хянуулсны дараа тухай бүрд нь жагсаалтаар олголт хийгдэж байна. 2025 оны хагас жилийн байдлаар нийт дүнгээр тэтгэмжийн сангийн зардал 8,184 сая төгрөгийн зардлаас 8,298.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 114.4 сая төгрөгийн хэтрэлттэй гарч байна. Батлагдсан төсвийн хуваарийн дагуу ажилгүйдлийн даатгалын сан дээр 3,871.9 сая төгрөгийн санхүүжилт авч 3,871.9 сая төгрөгийн зардал гарч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 400.0-550.0 сая	

						төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байна.	
2.4.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах	-	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийн саналыг Нийгмийн даатгалын багц хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлалын дагуу Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангуудын тайлан гаргах бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор тухайн ажил хариуцсан байцаагч, сан хариуцсан мэргэжилтэн нартай хамтран тооцоо нийлэх, тайлан гаргах хугацааг тусгаж тайлангийн хуваарь гарган газрын даргаар батлуулан хуваарийн дагуу ажилладаг. Харилцагч банкнууд тайлант хугацааны дансны үлдэгдлийн баталгаа тогтмол хийж хэвшсэн ба бусад байгууллагатай тооцоо нийлсэн актаар өглөг авлагын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж байна. Сангийн тайланг чанартай, цаг хугацаанд нь үнэн зөв гаргахад анхаарч ажиллаж байна. Сар бүрийн 2-ны дотор сангийн болон байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн болон	

						сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сангийн авлага өглөгийн мэдээ, харилцах дансны үлдэгдлийн мэдээ, тэтгэвэр тэтгэмж авагчдын тооны мэдээ, харилцах дансны нэгдсэн товчооны мэдээ зэрэг 8-н төрлийн мэдээг бэлтгэн гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.	
2.6.	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а) Нийгмийн даатгалын санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлэн ажилласан. НДЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 25 ний өдрийн 02 дугаар тоот “ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ”-ын удирдамжийн дагуу 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустлах хугацааны санхүүгийн болон холбогдох бичиг баримтуудыг шаардлагатай тухай бүрд нь баримт мэдээлэлээр хангаж 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ныг дуустал хугацаанд шалгуулж дууслаа. Мөн ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ-ны 2025 оны 01 дүгээр сарын	

						07-ны өдрийн 12-07/06 тоот АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ хяналт шалгалтын удирдамжийн дагуу ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэл, тэтгэмж олголттой холбоотой санхүүгийн болон холбогдох бусад баримт материалд үндэслэсэн шалгалтанд шаардлагатай баримт, мэдээллээр хангаж ажиллаа.	
2.7.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна.	НДЕГазартай байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу гэрээг бүтэн жилээр дүгнэн газрын даргатай хамтран дүгнэн НДЕГ-т хүргүүлэн ажиллалаа. Газрын даргын санаачлагаар, СБХ-ийн мэргэжилтнүүд хамтран ХААН банк, Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон зэрэг банкуудтай ажлын уулзалт зохион байгуулж хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх явцад гарч буй алдаа зөрчлийг нэг бүрчлэн хэлэлцэж цаашид тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал тавьж ажилласны дүнд харилцагч банкуудын алдаа гаргах явц багасаж уялдаа холбоотой ажиллах үр дүнтэй ажил болсон.	

2.8.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй, ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлэж ажиллаж байна.	
2.10.	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах	-	Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	Тэтгэвэр, тэтгэмжийн олголт жагсаалт файл бэлтгэх үед тухай банкны олгох тэтгэврийн сард олговол зохих дүнгээр бэлдсэн эсэхийг мөн тэтгэмжийн жагсаалтаар тухайн байгууллагын нэхэмжлэлийн дүн, дансны дугаар зөв эсэхийг тодруулж шалгасны дараа гүйлгээ гарган ажиллаж байна. Улирал бүр тайланг шалгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулан шалгаж тайлангийн хаалтыг тухай бүрд нь хийж байна. Ажил олгогч байгууллагад ХЧТА-ны болон Жирэмсэн амаржсны тэтгэмж илүү олгогдсон тохиолдолд тухайн ажил олгогчоос авлагаар бүртгэлд тусгаж тооцоо нийлэн албан бичиг хүргүүлж харилцах дансанд төлүүлж байна. 2024 оны жилийн	

						эцсийн тайлангаар тэтгэмжийн даатгалын сан 23.5 сая төгрөгийн авлагатай гарснаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар 12.7 сая төгрөгөөр нэмэгдэж 6.9 сая төгрөгөөр барагдаж нийт 29.3 сая төгрөгийн авлага барагдуулахаар ажиллаж байна. Харин ажилгүйдлийн даатгалын сангийн хувьд 2024 оны жилийн эцсийн тайлангаар 41.6 сая төгрөгийн авлагатай гарснаас 4.2 сая төгрөгийн авлага барагдаж 37.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.	
--	--	--	--	--	--	---	--

**ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

3.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих;	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.	Шилэн дансны хөтлөлтийн 2025 оны эхний хагас жилийн нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	
-----	---	---	--	--	--	--	--

**ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ**

Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж,

хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.6.	Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;		Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна.	Салбарын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн.		Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд ХАСХОМ бөглөсөн. Чанарын удирдлагын тогтолцоо ISO стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5С зарчийг хэрэгжүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна.	
------	--	--	---	---	--	---	--

Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.2.2	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	-	Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажиллах, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2025 оны эхний хагас жилд 100 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна мөн ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж хугацаанд нь хариу мэдээлэл хүргэн	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан, хагас жилийн хугацаанд иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн 8 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж хугацаанд нь хариу мэдээлэл хүргэн ажиллаж байна.	
-------	--	---	--	---	--	--	--

					ажиллаж байна.		
4.2.3	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;	-	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг -“Рийл” улиралд 3-аас доошгүй удаа; -“Постер” сард 3-аас доошгүй удаа; -“Видео контент” улиралд 1 удаа; Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа;	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээлэл, Рийл, Постер, Видео контентийг тогтмол түгээж ажилласан.	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			

1	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг судлах	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар цогц мэдлэг эзэмшсэн байна	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлтүүд, шинээр хэрэгжиж байгаа хуулийн зохицуулалтуудын талаар цогц мэдлэг эзэмших, мэргэшсэн чадварлаг албан хаагч болох Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, тогтоол, тушаал, заавар, зөвлөмж, аргачлал, зэргийг газрын зүгээс алба хаагчдад таниулцуулсны дагуу дээд газраас ирүүлсэн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмжийг хүлээн авч тухай бүр судалж мэдлэг чадвараа дээшлүүлж ажиллаж байна.
2	Excel программыг сурах,	Excel программыг албан хэрэглээний түвшингээс ахисан түвшинд эзэмшсэн байна	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасны дагуу богино болон дунд хугацааны сургалтад цахимаар хамрагдаж, Excel программыг албан хэрэглээний түвшингээс ахиулан эзэмшиж ажилдаа өдөр бүр хэрэглэж байна.
3	Монгол бичиг сурах	Монгол хэл бичгийн чадварын түвшин ахисан байх	Монгол хэл бичгийн анхан шатны мургалтанд цахимаар суралцсан.

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
1	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	-Байгууллагын удирдлагын хурал зөвлөгөөнд цаг тухай бүрт хамрагдаж өгсөн үүрэг даалгаварыг түргэн шуурхай хийж гүйцэтгэх.	Газрын даргын өгсөн үүрэг даалгаварын цаг тухай бүрт нь биелүүлэн ажиллаж байна.
			Ажлын цаг ашиглалт сайн баримталж, дүрэмт хувцсыг стандартын дагуу өмсөж хэвшсэн
			Жендэрийн үндэсний хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “харилцан хүндэтгэе” аянд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын хамт олон нэгдэж “Хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриатай Рийл бэлтгэж газрын Facebook хуудас болон дүүргийн ИТХ-ыг цахим хуудсаар дамжуулан түгээж, олон нийтийг зөрөг хандлагад уриалж ажиллалаа. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээлэл, Рийл, Постер, Видео контентийг тогтмол түгээж ажилласан. 2025 оны 02 дугаар сарын 20-ны Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2/511 тоот албан бичгийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээнд оролцсон. 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спорт хорооноос ирүүлсэн 35 тоот албан бичгийн дагуу ажлын байрны дасгал сургалтанд хамрагдсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан спорт заалаар үйлчлүүлэх ажлын хүрээнд дүүргийн биеийн тамир спорт хорооноос баталсан хуваарийн дагуу лхагва гариг бүр Нийслэлийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн спорт зааланд заал авч байгаа. 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/354 дүгээр захирамжийн хүрээнд Чингэлтэй дүүргийн засаг даргын Тамгын газраас ирүүлсэн удирдамжийн дагуу хаврын их цэвэрлэгээнд оролцсон. Төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсон тухай зөвлөмжийн дагуу Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 3/346 тоот албан бичгийн дагуу 2 дугаар сарын 20-ны өдрөөс Пүрэв гариг болгон зохион байгуулж байгаа Монгол бичгийн сургалтанд хамрагдсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хэлтэсээрээ хамрагдлаа. 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэйн фестиваль-д хамт олноороо

			үндэсний хувцасаараа гоёж оролцлоо.
		94047790 утасны дуудлага бүрийг алдалгүй иргэдэд мэдээлэл өгч ажиллах.	Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 94047790 утасны дуудлага хүлээн авч иргэдтэй холбогдон санал хүсэлтийг хүлээн авч тодорхой хариулт, мэдээллийг шалгаж хариултыг өгч ажиллаж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН САНГИЙН
БҮРТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



А.СЭЛЭНГЭЭ

2025 оны 06 дугаар сарын 06